



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЦӨМ
ХӨТӨЛБӨРТ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ
САНАА, АГУУЛГА, АРГА ЗҮЙ ТУСГАГДСАН
БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Баримт бичгийн судалгаа

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



UPPSALA
UNIVERSITET

IZB
Institute for International
Cooperation in Education
University of Teacher
Education Zug

Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл

2018 он

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх баг

А.Туяа (МУБИС-ийн Багшийн хөгжлийн төв, Ph.D)
Н.Нэргүй (Тэгш таван ухаан НҮТББ, Ph.D)
Ч.Нямгэрэл (МУИС, Ph.D)
Э.Шинэцэцэг (Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв, НҮТББ)

Дэд багууд

Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн судалгааны баг

Багийн ахлагч:

А.Энхтогтох (БХ)

Гишүүд:

Д.Цогзолмаа (БХ)

Х.Энхжаргал (БХ)

Б.Батчимэг (БХ)

Р.Содномцэрэн (ТЗДС)

Суурь, бүрэн дунд боловсролын хэл, хүмүүнлэгийн сургалтын хөтөлбөрийн судалгааны баг

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг (БМДИ)

Гишүүд:

Б.Цасанчимэг (БМДИ)

Б.Батчимэг (БХ)

Л.Уртнасан (МУБИС, Ph.D)

Э.Даваахүү (БМДИ)

Х.Энхжаргал (БХ)

Г.Чулаанаа (МУБИС)

А.Ирээдүй (БМДИ, Ph.D)

Суурь, бүрэн дунд боловсролын байгалын ухааны сургалтын хөтөлбөрийн судалгааны баг

Багийн ахлагч:

Т.Ганбаатар (МУБИС, Ph.D)

Гишүүд

Н.Сайнбаяр (БМДИ)

М.Оюунчимэг (БМДИ)

Ч.Нямгэрэл (МУИС, Ph.D)

З.Баярмаа (Орхон-Хасу ОУ хөтөлбөрийн ЕБС)

Д.Цэдэвсүрэн (МУБИС, Ph.D)

Б.Нармандах (МУБИС)

Нийгмийн ухаан, сургалтыг дэмжих үйл ажиллагаа сургалтын хөтөлбөрийн судалгааны баг

Багийн ахлагч:

У.Туяа (БХ, Ph.D)

Гишүүд

О.Оюунтунгалаг (БМДИ)

Ч.Гажиддулам (БМДИ)

АГУУЛГА

I.	УДИРТГАЛ	3
	1.1 Хэрэгцээ, үндэслэл	3
	1.2 Зорилго, зориулалт	3
	1.3 Бүтэц, агуулга хязгаарлалт	4
	1.4 Арга, аргачлал	5
	1.5 Шалгуур, индикатор, бенчмарк	5
II.	ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО БА ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	12
	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд	12
	B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд.	27
	C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд.	40
	D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд	52
III.	ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	66
	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд.	66
	B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд.	71
	C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд.	76
	D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулгын шинжилгээний үр дүнгүүд	81
IV.	ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АРГА БА ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	86
	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд.	86
	B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд.	100
	C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд.	118
	D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулгын шинжилгээний үр дүнгүүд	134
	ЕРӨНХИЙ ҮР ДҮН	149
	СУДАЛГААНЫ ҮР ДҮН	159

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРТ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА, АГУУЛГА, АРГА ЗҮЙ ТУСГАГДСАН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

I. УДИРТГАЛ

1.1 Хэрэгцээ, үндэслэл

2005 оноос ерөнхий боловсролын сургалтын агуулгын стандартыг цогц чадамжинд суурилсан боловсролын стандарт болгон мөрдөж, улмаар ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн шилжилтийн хөтөлбөрөөр дамжуулан хичээл тус бүрт ТХБ-ийг тусгах зорилтыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Мөн боловсролын салбарт 2012 оноос хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээнд хийгдсэн чанарын шинэчлэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж байдаг.

Монгол Улс, Монголын боловсролын салбар нь ТХ, ТХБ-ын түүхэн хөгжлийн үе шат бүрийн Дэлхий нийтийн шинэ санаачлага, үйл хэргийг нүд салгалгүй ажиглаж, хөл алдалгүй зүтгэж ирсэн. Үүний нэг жишээгээр УИХ-аас 2015 онд нийгэм, эдийн засаг, бизнес, улс орны бүхий л салбарын хөгжлийг урт хугацаанд баримжаалсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон БСШУ-ны Сайдын 2015 оны А/458 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага” бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Эдгээр баримт бичгүүд нь ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, өөрчлөх ажлыг эрчимжүүлэх үйл явцыг дэмжсэн.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр 2015 оноос өнөөдрийг хүртэл хичээлийн 3 жил үр дүнтэй хэрэгжиж байна. Цаашид цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйг бусад улс орнуудын адилаар ЮНЕСКО-оос 2017 онд гаргасан “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” буюу “Education for Sustainable Development Goals” гэсэн баримт бичигт дэлгэрүүлэн тодорхойлсон тогтвортой хөгжлийг дэмжих суралцахуйн зорилтуудтай харьцуулан дүгнэж, уялдуулах эрэлт хэрэгцээ гарч байна.

1.2 Зорилго, зориулалт

Хөтөлбөрийн үнэлгээний гол зорилго нь бүх түвшний сургалтын хөтөлбөрт тусгагдсан тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулгыг “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” баримт бичигт дурдсан суралцахуйн зорилт, агуулгын сэдвүүд, арга зүйн хандлагатай харьцуулан дүгнэх, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг боловсруулахад оршино.

Дэлхий нийтээр боловсролын алсын хараа шинэчлэгдэж буй энэхүү эргэлтийн шинжтэй энэ цаг үед одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг дээрх үзэл баримтлалын үүднээс нягтлан судалж үндэсний болон салбарын түвшиний мэргэжилтнүүдэд цэгцтэй, мэдээлэл өгөхөд дэмжлэг үзүүлэл зориулалттай.

1.3 Бүтэц, агуулга хязгаарлалт

Судалгаа нь үндсэн 4 бүлэг, 17 дэд бүлэг бүхий, ерөнхий үр дүн, судалгааны үр дүн бүхий бүтэцтэй.

Бүлэг	Дэд бүлэг
-------	-----------

I. УДИРТГАЛ	1.1 Хэрэгцээ, үндэслэл 1.2 Зорилго, зориулалт 1.3 Бүтэц, агуулга хязгаарлалт 1.4 Арга, аргачлал 1.5 Шалгуур, индикатор, бенчмарк
II. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО БА ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд
III. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулгын шинжилгээний үр дүнгүүд
IV. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АРГА БА ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд B. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд C. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд D. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулгын шинжилгээний үр дүнгүүд
ЕРӨНХИЙ ҮР ДҮН	<ul style="list-style-type: none"> - Дүгнэлт - Ололт амжилт - Алдаа, дутагдал, сургамж - Шийдвэрлэх асуудал - Санал, зөвлөмж
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	

Тус судалгаа нь хэрэгжүүлэх хугацаа, батлагдсан дизайн зэргээс хамаарч дор дурдсан хязгаарлалттай байна.

1. Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжинд ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны тусгайлсан багаж, хэрэгсэл, болон 2015 оноос хойш ТХ, ТХБ-ын чиглэлээр гарсан ЮНЕСКО-ын баримт бичиг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны материалуудад төвлөрсөн.
2. Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны объектийг ерөнхий боловсролын сургуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж гэсэн үндсэн баримт бичгүүдээр хязгаарласан.

1.4 Арга, аргачлал

Баримт судалгааны үндсэн арга (desk review)-ыг сонгосон тул баримт бичиг цуглуулж, түүнийг боловсруулах задлан шинжлэх, жиших, харьцуулах зэрэг танин мэдэхүйн барилууд болон компьютерийн шаардлагатай программуудыг ашиглан дараахи аргачлалаар боловсруулсан.

1. Тус судалгааны ажлыг гүйцэтгэхэд зөвлөх баг, судлагдахууны 4 дэд баг нийт 28 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг бүрдүүлсэн бөгөөд нэгдсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж зөвлөх багаас дэд багийн ахлагчдад, дэд багийн ахлагчдаас гишүүдэд судалгааны арга зүй, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх, нэгтгэх “шаталсан” зарчмаар ажилласан.
2. ТХ, ТХБ, ТХЗ, ТБ-ын цогц чадамжийн чиглэлээр сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-оос гаргасан онол, арга зүйн удирдамжийн баримт бичиг, гарын авлагыг судалж улмаар “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилтууд (ТХЗБ)” буюу “Education for Sustainable development goals: Learning Objectives”(2017) болон “Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан-Хүмүүс гараг дэлхийн төлөө боловсрол (БХШДТ)” буюу “Global education monitoring report-Education for people and planet” (2016) баримт бичгүүдийн онол, арга зүйд тулгуурлан тус судалгааны шалгуур үзүүлэлтийг боловсруулсан
3. ТБ-ын 8 цогц чадамж, ТХ-ийн 17 зорилтын хүрээнд 255 суралцахуйн зорилт, 171 сэдэв, 119 арга зүйн хандлага, арга техник болон БХШДТ-ын глобал үзүүлэлт 4.7.1-д дурдсан 4 бүлгийн 29 агуулгад тус тус суурилсан шалгуур үзүүлэлтийн дагуу 2 матрицыг бүтээж ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн 46 судлагдахууны зорилго, зорилт, үнэлгээ, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнд хэрхэн интеграцчилагдсан байдалд үнэлгээ хийсэн.
4. Боловсролын 3 түвшинд нийт 4 чиглэлийн 46 судлагдахуунаар үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг боловсруулсан.

Судалгааны тайланд шаардлагатай гэж үзсэн эх баримтууд болон тусгайлан боловсруулсан дэлгэрэнгүй мэдээллийг бие даасан хавсралтууд болгон бэлтгэж, хавсаргав.

1.5 Шалгуур, индикатор, бенчмарк

Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг үнэлэхийн тулд цөм хөтөлбөрийн судлагдахууны *суралцахуйн зорилго, зорилт, үнэлгээг* 8 шалгуур, 26 индикатор, *судлагдахууны агуулгыг* 4 шалгуур 29 индикатор, *судлагдахууны арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг* 4 шалгуур 20 индикатор гэсэн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг үнэлэх 4 төрлийн зориулалттай нийт 16 шалгуур, 75 индикатор бүхий EXCEL программ дээр суурилсан багаж, хэрэгсэлийг боловсруулан үнэлсэн.

Ерөнхий хэсэг болон агуулга хэсгээс бусад шалгуур, индикаторыг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагыг бүтээх явцад тусгайлан боловсруулагдсан багаж, хэрэгсэл болох Матриц-1, Матриц-2-ыг үндэслэн тэмдэглэгдсэн сурах бичиг, бусад эх үүсвэр, эсвэл тухайн судлаачийн бодлоор тодорхойлогдсон байж болох боломжуудыг хасан цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж хоёрыг дахин сайн нягтлаад орхигдсон зүйлийг нэмж бүртгэх зарчмаар ажилласан.

Хөтөлбөрийн зорилго, зорилт, үнэлгээнд

ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилго, зорилт, үнэлгээ нь Тогтвортой байдлын Цогц Чадамж (ТБЦЧ)-ийн төлөвшилд аль хэр хувь нэмэр оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлэхэд чиглэсэн.

Тогтвортой байдлын Цогц Чадамж (ТБЦЧ)-ийг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.1. Цогц чадамж, Тогтвортой байдлын цогц чадамж” дэд бүлэгт орчуулан, дэлгэрүүлэн тайлбарласнаар хэрэглэсэн.

Бенчмаркийг шалгуур тус бүрээр өндөр, дунд, бага гэсэн 3 түвшинд авч үзсэн бөгөөд үүгээр тухайн судлагдахууны зорилго, зорилт, үнэлгээ нь ТБЦЧ-ийн төлөвшилд аль хэр хувь нэмэр (хангалттай, дунд зэрэг, хангалтгүй) оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлж судалгааны үр дүн дүгнэлтийг боловсруулсан.

Тогтвортой байдлын 8 цогц чадамж: 26 индикатор

ЮНЕСКО-ийн “ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилт” баримт бичигт “Key competencies for sustainability” гэж томъёолон ТХ-ын төлөөх боловсролыг суралцахуйн бихеворист шинжийг илүү тодруулан өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн онцлогоос үл хамааран “дэлхийн хэмжээнд бүх насны суралцагчдад заавал төлөвшсөн байх” гэдэг утгаар хэрэглэсэн байна.

Судлаач de Naan, M.Reickmann, A.Wiek нарын судалгааны үр дүнг үндэслэн Дэлхийн хэмжээнд бүх насны суралцагчдад заавал төлөвшсөн байх, ТБ-ын түлхүүр 8 цогц чадамжийг нэрлэсэн байна.

№	Шалгуур	Индикатор
1	1. Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж (Systems thinking competency):	1. аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэн, ойлгох чадвар
2		2. нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар
3		3. тогтолцоо нь төрөл бүрийн ай болоод хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг тухай сэтгэн бодох чадвар
4		4. тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар
5	2. Урьдчилан тооцоолох цогц чадамж (Anticipatory competency):	1. боломжтой, магадлалтай, эсвэл хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар
6		2. ирээдүйд зориулан өөрийн үзэл бодол, дүр зургийг бий болгох чадвар
7		3. урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар
8		4. үйлийн үр дагаврыг үнэлж, дүгнэх чадвар
9		5. эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар
10	3. Хэм хэмжээний цогц чадамж (Normative competency):	1. хэн нэгний үйл, хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээ, үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар
11		2. тогтвортой байдлын үнэт зүйл, зарчим, зорилго, зорилтын талаар ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан ашигтай, тодорхойгүй мэдлэг чадвартай, эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөл байдалд ч хэлэлцээр хийх чадвар

12	4. Стратегийн цогц чадамж (Strategic competency):	1. орон нутгийн болон илүү өргөн хүрээнд цаашдын тогтвортой байдлыг дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулж, хэрэгжүүлэх чадвар
13		2. тухайн асуудлын төлөв байдалд интервенц, шилжилт хийх, засаглалыг хувирган өөрчилж, сайжруулах стратегийн хувилбарууд боловсруулах, сонгох чадвар
14	5. Хамтран ажиллах цогц чадамж (Collaboration competency):	1. бусдаас суралцах чадвар
15		2. бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх чадвар (өөрийгөө бусдын оронд тавьж ойлгох чадвар)
16		3. бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах чадвар (сэтгэл санааны манлайлал)
17		4. багаараа хамтран аливаа зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар
18		5. асуудлыг шийдвэрлэхэд оролцоог ханган хамтын хүчийг зохицуулах чадвар
19	6. Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж (Critical thinking competency):	1. тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар
20		2. өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар
21		3. тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар
22	7. Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж (Self-awareness competency):	1. дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх, эргэцүүлэн бодох чадвар
23		2. өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ дүгнэлт өгч, цаашид урам зориг өгөх чадвар
24		3. өөрийн мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадвар
25	8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж (Integrated problem-solving competency):	1. ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар
26		2. ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад цогц чадамжуудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ шаардлага (inclusive) ба эрх тэгш байдал (equitability)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар

Хөтөлбөрийн агуулгад

Ирэх арван таван жилийн туршид боловсролын талаарх тогтвортой хөгжлийн зорилтууд, мөн бусад зорилго дах боловсролын тухай асуудлаар хараат бус хяналт шинжилгээ, тайлагналыг хангах зорилгоор бүтээгдсэн “Боловсролын хяналт, шинжилгээний дэлхийн тайлан-2016” нь “Хүмүүс, гараг дэлхийн төлөө боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь” сэдэвтэйгээр боловсруулагдаж ТХЗ-ын 4 дэх зорилтод хийсэн хяналт үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсрол болон тогтвортой хөгжлийн бусад салбар хоорондын уялдаа холбоог цогц байдлаар нь танилцуулсан.

Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан-2016 нь глобал үзүүлэлтүүдэд ихээхэн анхаарал хандуулсан ба ерөнхий тогтолцооны арга хэмжээ, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, түүнчлэн багшийг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт дэлхийн иргэншил, тогтвортой хөгжлийн боловсролыг ямар агуулга, хэлбэрээр оруулах боломжтой талаар глобал болон сэдэвчилсэн үзүүлэлт хүрээнд шалгуур индикаторуудыг санал болгон танилцуулж дүн шинжилгээ хийсэн байна.

Энэхүү тайланд Дэлхийн иргэнийг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгыг хангах үндсэн арга нь сургалтын хөтөлбөр хэмээн үзэж улмаар хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайвныг эрхэмлэх соёл, хүчирхийллийг үл тэвчих байдал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маягийг дээшлүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар үндэсний сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгагдсан байдлыг үнэлэхэд чиглэжээ.

Бенчмаркийг эдгээр хэсэг тус бүрт хамаарах 29 орчим нэр томъёо агуулга нь ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгагдсан байдлаар нь бага, дунд хангалттай гэсэн 3 түвшинд үнэлж судалгааны үр дүн дүгнэлтийг боловсруулсан.

Мөн хэсэг тус бүрт хамаарах 29 орчим нэр томъёо агуулга нь ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.3. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын сэдэв” дэд бүлэгт дурдсан ТХЗСЗ удирдамжид санал болгосон 17 зорилгын 171 сэдэвтэй уялдуулах байдлаар харгалзуулсан болно.

ТХБ-ын сэдэвчилсэн үзүүлэлтүүд 4 хэсгийн: 29 индикатор, 171 сэдэв

№	Шалгуур	Индикатор	Хамаарах сэдэв
1	Gender equality- Жендерийн тэгш эрх	1. gender equality,-Жендерийн тэгш байдал/боломж	ТХ303.Сэ02, ТХ304.Сэ04, ТХ305.Сэ01-Сэ10, ТХ306.Сэ10, ТХ307.Сэ10, ТХ308.Сэ07, ТХ310.Сэ01, ТХ311.Сэ01
2		2. gender equity- Жендерийн тэгш эрх/нөхцөл/ үйл алагчлах	ТХ303.Сэ02, ТХ304.Сэ04, ТХ305.Сэ01-Сэ10, ТХ306.Сэ10, ТХ307.Сэ10, ТХ308.Сэ07, ТХ310.Сэ01, ТХ311.Сэ01
3		3. empowerment of girls/women-Охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх	ТХ304.Сэ10, ТХ305.Сэ01-Сэ10, ТХ311.Сэ01
4		4. gender sensitive (ity) and -Жендерийн мэдрэмжтэй	ТХ301.Сэ10, ТХ305.Сэ01-Сэ10, ТХ310.Сэ07, ТХ311.Сэ01
5		5. gender parity.-Жендерийн харьцаа	ТХ305.Сэ01-Сэ10, ТХ311.Сэ01
6	Human rights-Хүний эрх	1. human rights, rights and responsibilities (children’s rights, cultural rights, indigenous rights, women’s rights, disability rights); Хүний эрх ба үүрэг хариуцлага (хүүхдийн эрх, хэл, соёлын эрх,уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх)	ТХ301.Сэ06, ТХ304.Сэ04, Сэ10, ТХ305.Сэ04, Сэ05, ТХ306.Сэ02, Сэ04, ТХ307.Сэ5, ТХ316.Сэ05,
7		2. freedom (of expression, of speech, of press, of association or organization) and civil liberties; эрх чөлөө (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө) ба иргэний эрх чөлөө	ТХ316.Сэ06
8		3. social justice; Нийгмийн шударга ёс	ТХ301.Сэ04, ТХ308.Сэ02, ТХ313.Сэ11, ТХ316.Сэ01-10
9		4. democracy/democratic rule, democratic values/ principles; and; ардчилал/ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс/ардчилсан зарчим	ТХ316.Сэ01-10, ТХ317.Сэ02, Сэ03
10		5. human rights education; хүний эрхийн боловсрол	ТХ301.Сэ06, ТХ316.Сэ01-10
11	Sustainable development-тогтвортой хөгжил	1. sustainable, sustainability, sustainable development; тогтвортой, тогтвортой байдал, тогтвортой хөгжил	ТХ301.Сэ05-Сэ09, ТХ302.Сэ05, Сэ06, Сэ08, ТХ304.Сэ08, ТХ306.Сэ10, ТХ308.Сэ10, ТХ309.Сэ07, Сэ06, ТХ311.Сэ01-Сэ10, ТХ317.Сэ08,Сэ09, Сэ10
12		2. economic sustainability, sustainable growth, sustainable production/consumption, green economy; эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл, ногоон эдийн засаг	ТХ301.Сэ04, ТХ302.Сэ07-Сэ09,ТХ304.Сэ04, ТХ306.Сэ09, ТХ307.Сэ02, ТХ308.Сэ01-Сэ10, ТХ310.Сэ05, Сэ08, ТХ312.Сэ01-Сэ10, ТХ316.Сэ04, ТХ317.Сэ03
13		3. social sustainability (social cohesion and sustainability); нийгмийн тогтвортой байдал (нийгмийн эв нэгдэл ба тогтвортой байдал)	ТХ301.Сэ01, Сэ04, Сэ07, Сэ08, ТХ302.Сэ01, Сэ02, Сэ06, ТХ303.Сэ01-Сэ10, ТХ304.Сэ04, ТХ305.Сэ07, ТХ310.Сэ04, ТХ316.Сэ09, ТХ317.Сэ03
14		4. environmental sustainability/environmentally sustainable; хүрээлэл орчны орчны тогтвортой байдал/тогтворжсан байдал	ТХ302.Сэ03, Сэ09, ТХ303.Сэ10, ТХ306.Сэ01-Сэ10, ТХ311.Сэ04, Сэ05, Сэ08, ТХ314.Сэ01-10, ТХ315.Сэ01-10,

15		5. climate change/variability (global warming, carbon emissions/footprint); уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал (дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулал/ ул мөр)	TX302.Сэ03, TX305.Сэ08, TX306.Сэ02, TX307.Сэ06, TX313.Сэ01-Сэ10, TX314.Сэ06, TX315.Сэ05, TX316.Сэ03
16		6. renewable energy/fuels, alternative energy sources (solar, tidal, wind, wave, geothermal, biomass); сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч (нарны, далайн түрлэгийн, салхины, далайн давлагааны, гүний дулааны, биомассын)	TX307.Сэ01-Сэ10, TX311.Сэ02, Сэ03, TX312.Сэ01, Сэ04, Сэ10, TX314.Сэ03
17		7. ecosystems, ecology (biodiversity, biosphere, biomes, loss of diversity); экосистем, экологи (биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол)	TX302.Сэ03, Сэ10, TX306.Сэ01, Сэ07, TX311.Сэ05, TX312.Сэ05, TX313.Сэ10, TX314.Сэ01-10, TX315.Сэ01-10,
18		8. waste management, recycling; хог хаягдлын менежмент, дахин боловсруулах	TX309.Сэ01, TX311.Сэ07, TX312.Сэ07, TX314.Сэ08
19		9. education for sustainable development, sustainability education, education for sustainability; тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой байдлын боловсрол, тогтвортой байдлын төлөөх боловсрол	TX301.Сэ05, Сэ08, Сэ09, TX304.Сэ01-Сэ10, TX313.Сэ11, TX315.Сэ08, TX317.Сэ09
20		10. environmental education/studies, education for the environment, education for environmental sustainability; хүрээлэл орчны боловсрол/судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол	TX313.Сэ11, TX315.Сэ08, TX317.Сэ09
21	Global citizenship- Дэлхийн иргэншил	1. globalization; даяаршил	TX313.Сэ07, Сэ08, Сэ09, Сэ11, TX314.Сэ07, TX317.Сэ01-10
22		2. global citizen(ship)/culture/identity/community; дэлхийн иргэн/иргэншил/соёл/өвөрмөц байдал/ олон нийт)	TX301.Сэ02, TX302.Сэ04, Сэ05, TX307.Сэ07, Сэ08, TX317.Сэ05
23		3. global-local thinking, local-global (think global[ly] act local[ly], glocal); дэлхийн-орон нутгийн хэмжээнд сэтгэх, орон нутаг-дэлхий (дэлхийн хэмжээнд сэтгэж нутгийн хэмжээнд үйлд)	TX315.Сэ04, Сэ08, TX317.Сэ05
24		4. multicultural(ism)/intercultural(ism) (and hyphenated forms); олон талт соёл/ соёл хоорондын холимог (эрлийзчилсэн хэлбэр)	TX311.Сэ10, TX314.Сэ10, TX315.Сэ04
25		5. migration, immigration, mobility, movement of people; цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн	TX302.Сэ04, TX308.Сэ06, Сэ09, TX310.Сэ10, TX311.Сэ08, TX313.Сэ05, TX316.Сэ06
26		6. global competition/ competitiveness, globally competitive, international competitiveness; дэлхийн түвшний өрсөлдөөн /өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар	TX310.Сэ05, TX317.Сэ01, Сэ02, Сэ03, Сэ06, Сэ07
27		7. global inequality(ies)/disparity(ies); дэлхийн түвшин дэх тэгш бус байдал/ялгаатай байдал	TX301.Сэ02, Сэ03, Сэ04, Сэ07, Сэ08, TX302.Сэ02, TX303.Сэ02, TX305.Сэ03, TX306.Сэ03, TX308.Сэ08, TX310.Сэ01- Сэ10
28		8. national/local citizenship/culture/identity(ies)/ culture(s)/heritage, үндэсний/орон нутгийн иргэншил/ соёл/өвөрмөц байдал/ соёлын өв/дэлхийн иргэншлийн боловсрол	TX301.Сэ09, TX302.Сэ08, TX304.Сэ06, Сэ08, TX311.Сэ01, TX314.Сэ10, TX315.Сэ09, TX317.Сэ05
29		9. global citizenship education; and education for global citizenship; дэлхийн иргэншлийн боловсрол болон дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол	TX301.Сэ09, Сэ05, Сэ07, Сэ08, Сэ10, TX302.Сэ02, TX304.Сэ07, TX305.Сэ05, TX311.Сэ04, TX312.Сэ01, TX313.Сэ11, TX315.Сэ08, TX317.Сэ05

Хөтөлбөрийн арга зүй, орчин хэрэглэгдэхүүнд

ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн **арга зүй, орчин хэрэглэгдэхүүн** нь ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргуудад аль хэр хувь нэмэр оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлэхэд чиглэсэн.

ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргуудыг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.4. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын арга зүйн хандлага арга, техник” дэд бүлэгт орчуулан, дэлгэрүүлэн тайлбарласнаар хэрэглэсэн.

Бенчмаркийг шалгуур тус бүрээр өндөр, дунд, бага гэсэн 3 түвшинд авч үзсэн бөгөөд үүгээр тухайн судлагдахууны зорилго, зорилт, үнэлгээ нь ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргуудад аль хэр хувь нэмэр (хангалттай, дунд зэрэг, хангалтгүй) оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлж судалгааны үр дүн дүгнэлтийг боловсруулсан.

ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргууд 4 төрлийн: 20 индикатор

ЮНЕСКО-ын “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилтууд (ТХЗБ)” удирдамжид ТХЗ тус бүрээр сургалтын арга техникийн 7 жишээ, 17 зорилгоор нийт 119 жишээг өгсөн байна.

“ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагыг боловсруулах явцад судлаачид эдгээр 119 сургалтын арга техникийн жишээг харьцуулан судалж, 20 тодорхой аргыг ялган төрөлжүүлэн, ТХЗ-ын сургалтын түлхүүр 4 аргын аль төрөлд хамаарах байдлаар тодорхойсон байна.

№	Шалгуур	Индикатор
1	I. Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга	1. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх
2		2. Аян, кампанит ажилд оролцох, зохион байгуулах
3		3. Түншлэл (partnership)-ийг хөгжүүлэх
4		4. Дадалга (internship) хийх
5		5. Үйл ажиллагаанд оролцох, хамрагдах, төлөвлөх
6		6. Үйл ажиллагааны төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, оролцох
7		7. Видео үзэх
8	II. Шинжилгээ/ судалгаа хийх арга	1. Задлан шинжилгээ, судалгаа хийх
9		2. Тохиолдлын шинжилгээ
10		3. Шинжилгээнд суурилсан төсөл (enquiry-based project)
11		4. Туршилт хийх
12		5. Судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх
13	III. Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга	1. Эсээ бичих, хэлэлцүүлэг хийх
14		2. Дүрд хувиран тоглох
15		3. Экскурс, танилцах аялал
16		4. Вэб, блог хөтлөх, видео клип хийх
17	IV. Алсын хараатай болох арга	1. Хэтийн зорилго тодорхойлох
18		2. Түүх намтар зохиох
19		3. Ирээдүйд тодорхой нөхцөлд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
20		4. Үзэл баримтлал, зарчим боловсруулах

II. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО БА ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын зорилго ба үнэлгээ хэрхэн тусаж, интеграцчилагдсан байдлыг үнэлэхийн тулд Тогтвортой байдлын 8 цогц чадамжууд (ТБЦЧ)¹-ийг үнэлгээний шалгуураар тэдгээрт харгалзах 26 чадварыг индикатораар тус тус сонгож, хөтөлбөрийн зорилго ба үнэлгээнд хийсэн шинжилгээний үр дүнг танилцуулж байна.


ТБЦЧ нь “Тогтолцоон сэтгэлгээний цогц чадамж (ТСЦЧ)”, “Урьдчилан төсөөлөх цогц чадамж (УТЦЧ)”, “Хэм хэмжээний цогц чадамж (ХХЦЧ)”, “Стратегийн цогц чадамж (СЦЧ)”, “Хамтран ажиллах цогц чадамж (ХАЦЧ)”, “Шинжлэн судлах цогц чадамж (ШСЦЧ)”, “Өөрийгөө танин мэдэх цогц чадамж (ӨТМЦЧ)”, “Асуудал шийдвэрлэх цогц чадамж (АШЦЧ)” гэсэн 8 айтай.

Сургалтын хөтөлбөрт тодорхойлогдсон зорилго ба түүний хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний зорилго хоорондын тохирц, холбоо хамаарлыг үнэлж дүгнэх, цаашид сайжруулах үндэслэлийг гаргахад хөтөлбөрийн зорилго ба үнэлгээг хамтад нь нэг дор судлах нь зохистой гэж үзсэн болно.

A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний үр дүнгүүд

ЕБС-ийн 1-12 ангийн математик, байгалийн ухаан (БУ)-ны бүлэг хичээлийн хөтөлбөрийн шинжилгээнд математик, мэдээлэл зүй, физик, хими, биологи, газар зүйн сургалтын хөтөлбөрүүд, сурал гэсэн 6 судлагдахууны хөтөлбөр хамруулсан.

1. Хөтөлбөрийн зорилго ба үнэлгээнд бүртгэгдсэн ТБЦЧ-ийн чадваруудын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний шалгуураар)



Математик, БУ-ны бүлэг хичээлийн хувьд "Матриц 2"-оос нийт 282, "Цөм хөтөлбөр"-өөс нийт 148 хөтөлбөрийн зорилго тус тус бүртгэгджээ. Эндээс харахад Матриц 2-оос тодорхойлогдсон ТБЦЧ-ын тоо нь цөм хөтөлбөрт тодорхойлогдсон зорилгын тооноос даруй 48 хувиар илүү байна. Энэ нь Матриц 2-т цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжаас гадна сурах бичгүүдийг хамарсантай холбоотой. Хөтөлбөрийн

¹ 2018, БСШУЯ, БМДИ, ШХА, ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй. Хууд. 90-97


зорилгууд боловсролын түвшингөөр ямар тархалттай байгааг авч үзвэл, бүрэн дунд боловсролын түвшинд Матриц 2 ба Цөм хөтөлбөр дэх ТБЦЧ-уудын тархалт харьцангуй жигд байхад бага ба суурь боловсролын түвшинд жигд бус байна. Тухайлбал, цөм хөтөлбөрийн хувьд ТБЦЧ-ууд бага боловсролд дөнгөж 7% байхад суурь боловсролд бараг тал хувь (48%) ногдож байна (Зураг I.A.1.).

Энэ бүлэг хичээлийн хувьд "Матриц 2" ба "Цөм хөтөлбөр"-ийн аль алнийх нь суралцахуйн зорилгод ТБ-ын бүх 8 цогц чадамж илэрч бүртгэгдсэн ба тэдгээрийн тархалт ерөнхийдөө ижил дүр зурагтай байна. Тухайлбал, "Матриц 2" ба "Цөм хөтөлбөр" тус бүрийнх нь зорилгод ТСЦЧ (22, 25) ба УТЦЧ (26, 22) гэсэн хоёр шалгуурт харгалзах чадварууд нь бүх 8 шалгуурт харгалзах нийт чадварын бараг тал (48, 47) хувийг эзлэж байна. Харин ХХЦЧ, СЦЧ, АШЦЧ шалгуурт харгалзах чадварууд харьцангуй бага (5-8) хувийг эзлэж байна (Зураг I.A.1.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх боломжтой нийт 150 үнэлгээний зорилго бүртгэгджээ. Үүний 14% нь бага боловсролд, 40% нь суурь боловсролд, 46 хувь нь бүрэн дунд боловсролд илэрсэн байна. Үнэлгээний зорилгуудаас ТСЦЧ (26) ба УТЦЧ (21)-ын шалгуурт харгалзах чадварууд хамтдаа бүх 8 шалгуурт харгалзах чадваруудын 47% эзлэж байна. Энэ нь цөм хөтөлбөр дэх суралцахуйн ба үнэлгээний зорилгууд бүх шалгуурын хувьд харгалзан ойролцоо хувьтай байгааг харуулж байна (Зураг I.A.1.).

2. Хөтөлбөрийн зорилго ба үнэлгээнд бүртгэгдсэн ТБЦЧ-ийн чадваруудын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний индикатораар)

ТБЦЧ-ийн чадваруудаар илэрхийлэгдэх хөтөлбөрийн зорилго ба үнэлгээ




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 62 нь ТСЦЧ-д хамаарах бөгөөд 11 % нь бага, 44% нь суурь, 45% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 44 % нь ТСЦЧ-ийн аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1)-т; 20% нь нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2)-т; 37% нь тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг талаар сэтгэн бодох чадвар (1.3)-т тус тус бүртгэгдсэн бөгөөд харин нь тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4)-т боловсролын бүх түвшний хөтөлбөрийн зорилгод огт бүртгэгдээгүй байна (Зураг I.A.2.1.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс нийт 148 зорилгын 37 нь ТСЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 8% нь бага, 41% нь суурь, 51% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн

байна. Түүнчлэн ТСЦЧ-д хамаарах нийт чадварын 62% нь аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1)-т; 19% нь нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2)-т; 14% нь тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг талаар сэтгэн бодох чадвар (1.3)-т; 5% нь тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.1.). Энд аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1) нь ТСЦЧ-ын нийт чадварын 62 хувийг эзлэж байгаа онцлогтой байна. (Зураг I.A.2.1.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос ТСЦЧ-д хамаарах 39 чадвар бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 8% нь бага, 36% нь суурь, 56% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн 46% нь ТСЦЧ-ийн аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1)-т; 23% нь нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2)-т; 21% нь тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгддэг талаар сэтгэн бодох чадвар (1.3)-т; 10% нь тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.1.).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 72 нь УТЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 17% нь бага, 35% нь суурь, 49% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 21% нь УТЦЧ-ийн боломжтой, магадлалтай, хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар (2.1)-т; 10% нь ирээдүйн талаар өөрийн үзэл бодол, төсөөллийг бий болгох чадвар (2.2)-т; 38% урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар (2.3)-т; 22% нь үйлийн үр, дагаврыг үнэлж, дүгнэх чадвар (2.4)-т; 10% нь эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар (2.5)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.2.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн нийт 148 зорилгын 32 нь УТЦЧ-д хамаарах байгаа бөгөөд тэдгээрийн 9% нь бага, 39% нь суурь, 31% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн УТЦЧ-д хамаарах нийт чадварын 22% нь боломжтой, магадлалтай, хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар (2.1)-т; 6% нь ирээдүйн талаар өөрийн үзэл бодол, төсөөллийг бий болгох чадвар (2.2)-т; 28% урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар (2.3)-т; 25% нь үйлийн үр, дагаврыг үнэлж, дүгнэх чадвар (2.4)-т; 19% нь эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар (2.5)-т тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.A.2.2.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн УТЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос УТЦЧ-д хамаарах 31 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 13% нь бага, 39% нь суурь, 46% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 16% нь УТЦЧ-ийн боломжтой, магадлалтай, хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож,


үнэлэх чадвар (2.1)-т; 19% нь ирээдүйн талаар өөрийн үзэл бодол, төсөөллийг бий болгох чадвар (2.2)-т; 6% урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар (2.3)-т; адилхан 29% нь үйлийн үр, дагаврыг үнэлж, дүгнэх чадвар (2.4) ба эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар (2.5)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.2.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 19 нь ХХЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 21 % нь бага, 32% нь суурь, 47% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. ХХЦЧ-ийн хоёр индикатораар тодорхойлогдох чадваруудаас зөвхөн хэн нэгний үйл хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээ, үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар (3.1)-т 19 чадвар бүгдээрээ 100% харьяалагдаж байна. (Зураг I.A.2.3.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн хөтөлбөрийн нийт 148 зорилгын 8 нь ХХЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 12.5% нь бага, 50% нь суурь, 37.5% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн ХХЦЧ-ийн 87.5% нь хэн нэгний үйл хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээ, үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар (3.1)-т; 12.5% нь ТБ-ын үнэт зүйл, зарчим, зорилго, зорилтын талаар ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан ашигтай, тодорхойгүй мэдлэг чадвартай, эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөлд ч хэлэлцээр хийх чадвар (3.2)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.3.).


Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос ХХЦЧ-д хамаарах 10 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 30% нь бага, 40% нь суурь, 30% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 80% нь ХХЦЧ-ийн хэн нэгний үйл хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээ, үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар (3.1)-т; 20% нь ТБ-ын үнэт зүйл, зарчим, зорилго, зорилтын талаар ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан ашигтай, тодорхойгүй мэдлэг чадвартай, эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөлд ч хэлэлцээр хийх чадвар (3.2)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.3.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 22 нь СЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 41% нь бага, 36% нь суурь, 23% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 95% нь СЦЧ-ийн орон нутгийн болон илүү өргөн хүрээнд цаашдын ТБ-ыг дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт орноороо нэгдэн боловсруулж хэрэгжүүлэх чадвар (4.1)-т; 5% нь тухайн байдлын төлөв байдалд интервенц, шилжилт хийх, засаглалыг хувирган өөрчилж, сайжруулах стратегийн хувилбарууд боловсруулах, сонгох чадвар (4.2)-т тус тус бүртгэгдсэн байна. (Зураг I.A.2.4.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн хөтөлбөрийн нийт 148 зорилгын 7 нь СЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 14% нь бага, 71% нь суурь, 14% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 71% нь СЦЧ-ийн орон нутгийн болон илүү өргөн хүрээнд цаашдын ТБ-ыг дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт орноороо нэгдэн боловсруулж хэрэгжүүлэх чадвар (4.1)-т; 29% нь тухайн байдлын төлөв байдалд интервенц, шилжилт хийх, засаглалыг хувирган өөрчилж, сайжруулах стратегийн хувилбарууд боловсруулах, сонгох чадвар (4.2)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.4.).


Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос СЦЧ-д хамаарах 18 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 25% нь бага, 62.5% нь суурь, 12.5% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн 62.5% нь СЦЧ-ийн орон нутгийн болон илүү өргөн хүрээнд цаашдын ТБ-ыг дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт орноороо нэгдэн боловсруулж хэрэгжүүлэх чадвар (4.1)-т; 37.5% нь тухайн байдлын төлөв байдалд интервенц, шилжилт хийх, засаглалыг хувирган өөрчилж, сайжруулах стратегийн хувилбарууд боловсруулах, сонгох чадвар (4.2)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.4.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 32 нь ХАЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 38% нь бага, 22% нь суурь, 41% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 34% нь ХАЦЧ-ийн бусдаас суралцах чадвар (5.1)-т; 19% нь бусдын хэрэгцээ, шаардлага, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх (өөрийгөө бусдын байранд тавьж ойлгох) чадвар (5.2)-т; 6% нь бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах (сэтгэл санааны манлайлал) чадвар (5.3)-т; 16% нь багаараа хамтран аливаа зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар (5.4)-т; 25% нь асуудлыг шийдвэрлэхэд оролцоог ханган хамтын хүчийг зохицуулах чадвар (5.5)-т тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.A.2.5.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн нийт 148 зорилгын 21 нь ХАЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 6% нь бага, 43% нь суурь, 52% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн 43% нь ХАЦЧ-ийн бусдаас суралцах чадвар (5.1)-т; 19% нь бусдын хэрэгцээ, шаардлага, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх (өөрийгөө бусдын байранд тавьж ойлгох) чадвар (5.2)-т; 10% нь бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах (сэтгэл санааны манлайлал) чадвар (5.3)-т; 19% нь багаараа хамтран аливаа зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар (5.4)-т; 10% нь асуудлыг шийдвэрлэхэд оролцоог ханган хамтын хүчийг зохицуулах чадвар (5.5)-т тус тус бүртгэгджээ (Зураг I.A.2.5.).


Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшилийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос ХАЦЧ-д хамаарах 16 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 12.5% нь бага, 50% нь суурь, 37.5% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 19% нь ХАЦЧ-ийн бусдаас суралцах чадвар (5.1)-т; 25% нь бусдын хэрэгцээ, шаардлага, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх (өөрийгөө бусдын байранд тавьж ойлгох) чадвар (5.2)-т; 6% нь бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах (сэтгэл санааны манлайлал) чадвар (5.3)-т; 31% нь багаараа хамтран аливаа зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар (5.4)-т; 19% нь асуудлыг шийдвэрлэхэд оролцоог ханган хамтын хүчийг зохицуулах чадвар (5.5)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.5.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 28 нь ШСЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 21% нь бага, 43% нь суурь, 36% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 32% нь ШСЦЧ-ийн тогтсон хэм хэмжээ, дадал зуршил, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар (6.1)-т; 50% нь өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар (6.2)-т; 18% нь ТБ-ын төлөөх яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар (6.3)-т тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.A.2.6.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн нийт 148 зорилгын 21 нь ШСЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 4.8% нь бага, 47.6% нь суурь, 47.6% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 33% нь ШСЦЧ-ийн тогтсон хэм хэмжээ, дадал зуршил, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар (6.1)-т; 52% нь өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар (6.2)-т; 14% нь ТБ-ын төлөөх яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар (6.3)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.6.).


Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос ШСЦЧ-д хамаарах 15 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 13.3% нь бага, 33.3% нь суурь, 53.3% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 27% нь ШСЦЧ-ийн тогтсон хэм хэмжээ, дадал зуршил, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар (6.1)-т; 40% нь өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар (6.2)-т; 33% нь ТБ-ын төлөөх яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар (6.3)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.6.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 зорилгын 28 нь ӨТМЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 21% нь бага, 32% нь суурь, 46% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 89% нь ӨТМЦЧ-ийн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1)-т; 7% нь өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2)-т; 4% нь өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3)-т тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.A.2.7.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн нийт 148 зорилгын 12 нь ӨТМЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 8% нь бага, 50% нь суурь, 42% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 50% нь ӨТМЦЧ-ийн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1)-т; 33% нь өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2)-т; 17% нь өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.7.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос ӨТМЦЧ-д хамаарах 14 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 21.4% нь бага, 57.1% нь суурь, 21.4% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 35.7% нь ӨТМЦЧ-ийн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1)-т; 35.7% нь өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2)-т; 28.6% нь өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.7.).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 282 хөтөлбөрийн зорилгын 19 нь АШЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 53.6% нь бага, 15.8% нь суурь, 31.6% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Тэдгээрийн 42% нь АШЦЧ-ийн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1)-т; 58% нь ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive) ба үл алагчилах шударга байдал (equitablity)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2)-т тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.A.2.8.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн нийт 148 зорилгын 10 нь зорилгын ШСЦЧ-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 30% нь суурь, 70% нь бүрэн дунд боловсролын түвшинд илэрсэн ба бага боловсролын түвшинд энэ ЦЧ-ын нэг ч чадвар бүртгэгдээгүй байна. Түүнчлэн тэдгээрийн 80% нь АШЦЧ-ийн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1)-т; 20% нь ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive) ба үл алагчилах шударга байдал (equitablity)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2)-т тус тус бүртгэгджээ. (Зураг I.A.2.8.).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн ТБЦЧ-ийн төлөвшлийг үнэлэх нийт 150 үнэлгээний зорилгоос АШЦЧ-д хамаарах 17 чадвар илэрсэн бөгөөд тэдгээрийн 11.8% нь бага, 23.5% нь суурь, 64.7% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 88% нь АШЦЧ-ийн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1)-т; 12% нь ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive) ба үл алагчилах шударга байдал (equitablity)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2)-т тус тус харгалзаж байна (Зураг I.A.2.8.).


ТБЦЧ-ийн чадварууд илэрсэн судлагдахуунууд



Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос бүртгэгдсэн зорилгын тухайд ТСЦЧ-ийн аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1) бага боловсролын 2, суурийн 5, бүрэн дундын 4 судлагдахуунд; нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2) суурийн 3, бүрэн дундын 4 судлагдахуунд; тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг талаар сэтгэн бодох чадвар (1.3) суурийн 3, бүрэн дундын 4 судлагдахуунд тус тус бүртгэгдсэн байна. Харин ТСЦЧ-ийн тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4) бүх түвшний суралцахуйн зорилгод огт илрээгүй ба 1.2 болон 1.3 индикатороор илрэх чадварууд бага боловсролын нэг ч судлагдахуунд бүртгэгдээгүй байна (Зураг I.A.3.1).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн хөтөлбөрийн зорилгын тухайд ТСЦЧ-ийн аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1) бага боловсролын 2, суурь ба бүрэн дундын тус бүр 6 судлагдахуунд; нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2) бага боловсролд бүртгэгдээгүй ба суурийн 2, бүрэн дундын 3 судлагдахуунд; тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг талаар сэтгэн бодох чадвар (1.3) бага ба суурийн тус бүр 1; бүрэн дундын 3 судлагдахуунд; тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4) бүрэн дундын зөвхөн 1 судлагдахуунд илэрч, бусад түвшинд огт илрээгүй байна (Зураг I.A.3.1).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн үнэлгээний тухайд ТСЦЧ-ийн аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж, ойлгох чадвар (1.1) бага боловсролын 1, суурь ба бүрэн дундын тус бүр 4 судлагдахуунд; нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар (1.2) бага боловсролын аль ч судлагдахуунд илрээгүй ба суурийн 3, бүрэн дундын 4 судлагдахуунд; тогтолцоо нь төрөл бүрийн ай болон хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг талаар сэтгэн бодох чадвар (1.3) мөн бага боловсролын нэг ч судлагдахуунд илрээгүй ба суурийн 3, бүрэн дундын 4 судлагдахуунд тус тус илэрсэн байна. Харин тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4) боловсролын бүх түвшний үнэлгээнд огт илрээгүй байна (Зураг I.A.3.1).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос бүртгэгдсэн хөтөлбөрийн зорилгын тухайд УТЦЧ-ийн боломжтой, магадлалтай, хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар (2.1) бага ба суурь боловсролын тус бүр 2, бүрэн дундын 3 судлагдахуунд; ирээдүйн талаар өөрийн үзэл бодол, төсөөллийг бий болгох чадвар (2.2) бага боловсролын 1, суурийн 2,

бүрэн дундын 3 судлагдахуунд; урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар (2.3) бага боловсролын 2, суурийн 4, бүрэн дундын 3 судлагдахуунд; үйлийн үр, дагаврыг үнэлж, дүгнэх чадвар (2.4) бага боловсролын 1, суурийн 3; бүрэн дундын 2 судлагдахуунд; эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар (2.5) бага ба суурийн тус бүр 1, бүрэн дундын 3 судлагдахуунд тус тус илэрч бүртгэгдсэн байна (Зураг I.A.3.2).

Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн хөтөлбөрийн зорилгын тухайд УТЦЧ-ийн боломжтой, магадлалтай, хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар (2.1) бага боловсролын 1, суурийн 2, бүрэн дундын 3 судлагдахуунд; ирээдүйн талаар өөрийн үзэл бодол, төсөөллийг бий болгох чадвар (2.2) суурийн 1 судлагдахуунд илэрсэн бөгөөд бага ба бүрэн дундын аль ч судлагдахуунд илрээгүй байна. Харин УТЦЧ-ийн урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар (2.3) бага ба бүрэн дундын тус бүр 1, суурийн 5 судлагдахуунд илэрсэн бол үйлийн үр, дагаврыг үнэлж, дүгнэх чадвар (2.4) бага боловсролын нэг ч судлагдахуунд илрээгүй ба суурийн 4; бүрэн дундын 3 судлагдахуунд; эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар (2.5) бага боловсролын 1 суурь ба бүрэн дундын тус бүр 2 судлагдахуунд илэрсэн байна (Зураг I.A.3.2).

"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны зорилгын тухайд ШСЦЧ-ийн айн тогтсон хэм хэмжээ, дадал зуршил, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар (6.1) бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар (6.2) багын 2, суурийн 1 үйл ажиллагаанд; ТБ-ын төлөөх яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар (6.3) бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд бүртгэгдсэн байна (Зураг I.D.3.6.).


"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны үнэлгэний зорилгын тухайд ШСЦЧ-ийн айн тогтсон хэм хэмжээ, дадал зуршил, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар (6.1) суурьд илрээгүй ба багын 1 үйл ажиллагаанд; ТБ-ын төлөөх яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар (6.3) суурьд илрээгүй ба багын 1 үйл ажиллагаанд тус тус бүртгэгдсэн байна. Харин өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар (6.2) боловсролын аль ч түвшинд илрээгүй байна. (Зураг I.D.3.6.)



"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны зорилгын тухайд ӨТМЦЧ-ийн айн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1) багын 1, суурийн 2 үйл ажиллагаанд; өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2) багын 1, суурийн 3 үйл ажиллагаанд; өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3) багын 2, суурийн 1 үйл ажиллагаанд бүртгэгдсэн байна. (Зураг I.D.3.7.).

"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны зорилгын тухайд ӨТМЦЧ-ийн айн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1) бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2) бага болон суурийн тус бүр 2 үйл ажиллагаанд; өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3) багын 2, суурийн 1 үйл ажиллагаанд бүртгэгджээ. (Зураг I.D.3.7.).

"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны үнэлгээнй зорилгын тухайд ӨТМЦЧ-ийн айн дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх эргэцүүлэн бодох чадвар (7.1) багын 1, суурийн 2 үйл ажиллагаанд; өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ, дүгнэлт өгч, урам зориг авах чадвар (7.2) бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; өөрийн мэдрэмж, хүсэл зорилгоо авч үзэх чадвар (7.3) багад илрээгүй бөгөөд суурийн 1 үйл ажиллагаанд тус тус бүртгэгдсэн байна (Зураг I.D.3.7.).



"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны зорилгын тухайд АШЦЧ-ийн айн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1) багад илрээгүй ба суурийн 1 үйл ажиллагаанд; ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive) ба үл алагчилах шударга байдал (equitability)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2) суурьд илрээгүй ба багын 1 үйл ажиллагаанд тус тус бүртгэгджээ. (Зураг I.D.3.8.).

"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны зорилгын тухайд АШЦЧ-ийн айн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1) багад илрээгүй ба суурийн 1 үйл ажиллагаанд; ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive) ба үл алагчилах шударга байдал (equitability)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2) суурьд илрээгүй ба багын 1 үйл ажиллагаанд бүртгэгдсэн байна (Зураг I.D.3.8.).

"Цөм хөтөлбөр"-өөс бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны үнэлгээнй зорилгын тухайд АШЦЧ-ийн айн зөвхөн ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар (8.1) багад илрээгүй ба суурийн 1 л үйл ажиллагаанд бүртгэгдсэн байна. Харин ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад ЦЧ-уудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ (inclusive)

ба үл алагчилах шударга байдал (equitablity)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар (8.2) боловсролын аль ч түвшний үйл ажиллагаанд илрээгүй байна (Зураг I.D.3.8.).

III. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын агуулга хэрхэн тусаж, интеграцчилагдсан байдлыг үнэлэхийн тулд ТХЗ 4-ийн товлосон зорилт 4.7-ийн хэрэгжилтийг үнэлэх сэдэвчилсэн индикаторуудын нэг болох "Сургалтын хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилсан байх" гэсэн индикаторыг үнэлгээний шалгуур сонгох гол үндэслэл болгосон. ЮНЕСКО-ийн "Хүмүүс ба Дэлхий" нэртэй 2016 оны Дэлхий нийтийн Хяналт-Шинжилгээний Тайлан (ДХШТ-GMR)-д хэрэглэсэн ТХБ-ын агуулга (ТХБА)-ын 4 айг шалгуур, тэдгээрт харгалзах 29 сэдвийг индикатор болгон тус тус сонгож, хөтөлбөрийн агуулгад шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.

ТХБА нь "Жендэрийн тэгш эрх (ЖТЭ)", "Хүний эрх (ХЭ)", "Тогтвортой хөгжил (ТХ)", "Дэлхийн иргэнши (ДИ)" гэсэн 4 айтай.

A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд

ЕБС-ийн 1-12 ангийн математик, байгалийн ухаан (БУ)-ны бүлэг хичээлийн хөтөлбөрийн шинжилгээнд математик, мэдээлэл зүй, физик, хими, биологи, газар зүйн сургалтын хөтөлбөрүүд, сурал гэсэн 6 судлагдахууны хөтөлбөрийг хамруулсан. Шинжилгээг боловсролын бага, суурь, бүрэн дунд гэсэн 3 түвшингээр, ТХБА-ийн айн 4 шалгуур, сэдвийн 29 индикатораар явуулсан болно. ЕБС-ийн цөм хөтөлбөрүүдэд "агуулга" нь "суралцахуйн зорилтууд" хэлбэрээр тодорхойлогдсон байсан тул энэ судалгаанд хөтөлбөрийн агуулгыг үнэлэхдээ тэдгээр суралцахуйн зорилтуудаас энэ төрлийн судалгаанд зориулан судалгааны багаас тусгайлан бүтээсэн Матриц 2-ын тусламжтайгаар шинжлэх агуулгаа ялгаж үнэлсэн онцлогтой.

1. Хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба шалгуураар)




Математик, БУ-ны бүлэг хичээлийн хувьд цөм хөтөлбөрөөс "Матриц 2"-ын тусламжтайгаар ялгаж тодорхойлсон нийт 294 агуулга бүртгэгджээ. Тэдгээрийн 35% нь бага боловсролд, 2% нь суурь боловсролд, 40% нь бүрэн дунд боловсролд илэрсэн байна. (Зураг II.A.1.).


Математик, БУ-ны бүлэг хичээлийн хувьд "Матриц 2"-т тодорхойлогдсон хөтөлбөрийн агуулга нь ТХБ-ын агуулгын бүх 4 айд илэрч бүртгэгдсэн ба тэдгээрийн тархалт жигд бус байна. Тухайлбал, нийт бүртгэгдсэн 294 агуулгын 75% нь "Тогтвортой хөгжил" агуулгын айд илэрсэн байхад "Хүний эрх" агуулгын айд дөнгөж 2% нь илэрсэн байна. Мөн "Жендерийн тэгш эрх" ба "Дэлхийн иргэншил" гэсэн хоёр айд тус бүр 10 орчин хувь нь илэрчээ. (Зураг II.A.1.).

2. Хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний индикатораар)


ТХБА-тай холбогдох хөтөлбөрийн агуулга




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 294 агуулгын 37 буюу 12.6% нь ЖТЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 11 % нь бага, 89% нь суурь боловсролын түвшинд тус тус илэрч, бүрэн дундын түвшинд огт илрээгүй байна. Мөн ЖТЭ-ийн айд илэрсэн нийт агуулгын тус бүр 19% нь харгалзан жендерийн тэгш байдал (1.1) болон жендерийн харьцаа (1.5)-ны сэдэвт; 22-24% нь харгалзан жендерийн үл алагчилал (1.2) болон жендерийн мэдрэмж (1.4)-ийн сэдэвт; 16% нь охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3)-ийн сэдэвт тус тус холбогдон бүртгэгдсэн байна. (Зураг II.A.2.1.).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 294 агуулгын 7 буюу дөнгөж 2.4% нь ХЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 14 % нь суурь, 86% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрч, бага боловсролын түвшинд огт илрээгүй байна. Түүнчлэн ХЭ-ийн айд илэрсэн нийт агуулгын 14% нь нийгмийн шударга ёс (2.3)-ны сэдэвт; 29% нь эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2)-ний сэдэвт; 57% нь хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх,уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1)-ийн сэдэвт тус тус холбогдон бүртгэгдсэн байна. Харин ардчилал: ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4) ба хүний эрхийн боловсрол (2.5)-той холбоотой агуулга агуулгын энэ айд илрээгүй байна (Зураг II.A.2.2.).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 294 агуулгын 221 буюу дийлэнх нь (75%) нь ТХ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн тус бүр 26% нь бага ба суурь боловсролын, 48% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн ТХ-ийн айд илэрсэн нийт агуулгын 10% нь тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1)-ийн сэдэвт; 16% нь эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2)-ийн сэдэвт; тус бүр 17% нь нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл (3.3) болон хүрээлэл орчны тогтвортой байдал ба тогтворжсан байдал (3.4)-ын сэдэвт; 13-14% нь харгалзан уур амьсгалын өөрчлөлт,тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт, ул мөр (3.5) болон экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7)-ын сэдэвт; 5-6 % нь харгалзан сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч: нарны, далайн түрлэгийн, салхины, далайн давлагааны, гүний дулааны, биомассын (3.6) болон ТХБ, тогтвортой байдлын боловсрол, тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-ын сэдэвт; 1% нь хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10)-ын сэдэвт тус тус холбогдон бүртгэгдсэн байна. Харин хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-тай холбоотой сэдэв агуулгын энэ айд илрээгүй байна (Зураг II.A.2.3.).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 294 агуулгын 29 буюу 10 орчим хувь нь ДИ-ийн айд хамаарч байна. Тэдгээрийн 52% нь бага, 17% нь суурь, 31% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрчээ. Түүнчлэн ДИ-ийн айд илэрсэн нийт агуулгын 3-7% нь харгалзан даяаршил (4.1) болон дэлхийн иргэн ба иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийтийн бүлэг (4.2)-ийн сэдэвт; тус бүр 10% нь олон талт соёл ба эрлийзчисэн холимог соёл (4.4) болон цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5)-ний сэдэвт; 14% нь дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ буюу дэлхийн хэмжээнд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх (4.3)-ийн сэдэвт; тус бүр 17% нь үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8) болон дэлхийн иргэншлийн боловсрол, дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-ын сэдэвт; 21% нь дэлхийн түвшин дэх тэгш бус байдал, ялгаатай байдал (4.7)-ын сэдэвт тус тус холбогдон бүртгэгдсэн байна. Харин дэлхийн түвшний өрсөлдөөн ба өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6)-тай холбоотой сэдэв агуулгын энэ айд илрээгүй байна (Зураг II.A.2.4.).


ТХБА илэрсэн судлагдахуунууд



Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ЖТЭ-ийн айн жендерийн тэгш байдал (1.1)-д хамаарах агуулга бага боловсролын 1 судлагдахуунд; жендерийн үл алагчилал (1.2)-д хамаарах агуулга бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3)-д хамаарах агуулга бага боловсролын 1 судлагдахуунд; жендерийн харьцаа (1.5)-нд хамаарах агуулга бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд бүртгэгджээ. Харин бага боловсролын түвшинд ЖТЭ-ийн айд хамаарах агуулга индикатор бүрээр тус бүр 1 судлагдахуунд бүртгэгдсэн бол бүрэн дунд боловсролын түвшинд математик, БУ-ны бүх судлагдахуунд ЖТЭ-тэй холбоотой нэг ч агуулга бүртгэгдээгүй байна. (Зураг II.A.3.1).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарах нэг ч агуулга бага боловсролын аль ч судлагдахуунд, түүнчлэн ардчилал, ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4) болон хүний эрхийн боловсрол (2.5)-д хамаарах агуулга боловсролын бүх түвшний аль ч судлагдахуунд тус тус огт илрээгүй байна. Харин хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх,уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундын тус бүр 1 судлагдахуунд; эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2)-нд хамаарах агуулга суурийн 1 судлагдахуунд; нийгмийн шударга ёс (2.3)-нд хамаарах агуулга суурийн 1 судлагдахуунд тус тус бүртгэгджээ. (Зураг II.A.3.2).



Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ТХ-ийн айн тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1)-д хамаарах агуулга бага боловсролын 1, суурийн 2, бүрэн дундын 3 судлагдахуунд; эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2)-т хамаарах агуулга бага боловсролын 1, суурийн 4, бүрэн дундын 5 судлагдахуунд; нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл ба тогтвортой байдал (3.3)-д хамаарах агуулга бага боловсролын 3, суурийн 1, бүрэн дундын 2 судлагдахуунд; хүрээлэл орчны тогтвортой байдал ба огтворжсан байдал (3.4)-д хамаарах агуулга бага боловсролын 3, суурийн ба бүрэн дундын тус бүр 4 судлагдахуунд; уур амьсгалын өөрчлөлт,тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт/ ул мөр (3.5)-д хамаарах агуулга бага боловсролын 1, суурийн 2, бүрэн дундын 5 судлагдахуунд; сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч (3.6)-д хамаарах агуулга бага ба суурийн тус бүр 1, бүрэн дундын 5 судлагдахуунд; экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7)-д хамаарах агуулга бага боловсролын 2, суурийн 4, бүрэн дундын 3 судлагдахуунд; ТХБ, тогтвортой байдлын болон тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-д хамаарах агуулга бага боловсролын 1, суурийн 3, бүрэн дундын 1 судлагдахуунд; хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10)-д хамаарах агуулга бага боловсролын 1судлагдахуунд тус тус бүртгэгдсэн байна. Харин агуулгын ТХ-ийн айн хог хаягдлын

менежмент, дахин боловсруулалт (3.8)-д хамаарах агуулга аль ч түвшний судлагдахуунд илрээгүй байна. (Зураг II.A.3.3).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн нийт 6 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ДИ-ийн айн даяаршил (4.1)-д хамаарах агуулга бага ба суурийн аль ч судлагдахуунд илрээгүй ба бүрэн дундын 1 судлагдахуунд; дэлхийн иргэн, иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийт бүлэг (4.2)-т хамаарах агуулга бага боловсролд илрээгүй ббөгөөд суурь ба бүрэн дундын тус бүр 1 судлагдахуунд; дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ: дэлхийн хэмжээнд сэтгэж нутгийн түвшинд үйлдэх (4.3)-эд хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; олон талт соёл ба эрлийзчисэн холимог соёл (4.4)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундад илрээгүй ба бага боловсролын 1 судлагдахуунд; цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5)-нд хамаарах агуулга суурьд илрээгүй ба бага ба бүрэн дундад тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн түвшин дэх тэгш бус байдал/ялгаатай байдал (4.7)-д хамаарах агуулга бага ба суурьд илрээгүй ба бүрэн дундын 2 судлагдахуунд; үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн иргэншлийн боловсрол болон дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага боловсролын 1, суурийн 2 судлагдахуунд тус тус бүртгэгдсэн байна. Харин дэлхийн түвшний өрсөлдөөн/өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6)-т хамаарах агуулга боловсролын бүх түвшний аль ч судлагдахуунд огт илрээгүй байна. (Зураг II.A.3.4.).

В. Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд

ЕБС-ийн 1-12 ангийн хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн хөтөлбөрийн шинжилгээнд монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, англи хэл, орос хэл, хөгжим, дүрслэх урлаг, эрүүл мэнд, технологи, биеийн тамир 10 судлагдахууны хөтөлбөрийг хамруулсан.

1. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний шалгуураар)




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн хувьд цөм хөтөлбөрөөс "Матриц 2"-ын тусламжтайгаар ялгаж тодорхойлсон нийт 238 агуулга бүртгэгджээ. Тэдгээрийн 28% нь бага боловсролд, 56% нь суурь боловсролд, 16% нь бүрэн дунд боловсролд илэрсэн байна. (Зураг II.B.1.).


Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн хувьд "Матриц 2"-т тодорхойлогдсон хөтөлбөрийн агуулга нь ТХБ-ын агуулгын бүх 4 айд илэрч бүртгэгдсэн ба тэдгээрийн тархалт жигд бус байна. Тухайлбал, нийт бүртгэгдсэн 238 агуулгын 72% нь "Тогтвортой хөгжил" агуулгын айд илэрсэн байхад "Хүний эрх" агуулгын айд дөнгөж 3% нь илэрсэн байхад "Жендерийн тэгш эрх" айд 16%, "Дэлхийн иргэншил" 10% нь илэрчээ. (Зураг II.B.1.).

2. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний индикатораар)


ТХБА-тай холбогдох хөтөлбөрийн агуулга




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 238 агуулгын 37 буюу 15.5% нь ЖТЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 19% нь бага, 81% нь суурь боловсролын түвшинд тус тус бүртгэгдэж, бүрэн дундын түвшинд бүртгэгдээгүй байна. Түүнчлэн ЖТЭ-ийн айд хамаарах нийт агуулгын 22% нь жендерийн тэгш байдал (1.1) индикаторын хүрээнд; 30% нь жендерийн үл алагчилал (1.2) индикаторын хүрээнд; тус бүр 16% нь охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3) болон жендерийн мэдрэмж (1.4 мөн жендерийн харьцаа (1.5) гэсэн агуулгын 3 индикаторын хүрээнд тус тус илэрсэн байна. (Зураг II.B.2.1.).



Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 238 агуулгын 6 буюу дөнгөж 2.5% нь ХЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 83 % нь бага, 17% нь суурь боловсролын түвшинд тус тус илэрч, бага боловсролын түвшинд огт илрээгүй байна. Түүнчлэн ХЭ-ийн айд хамаарах нийт агуулгын 17% нь эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2) агуулгын хүрээнд; 50% нь нийгмийн шударга ёс (2.3) агуулгын хүрээнд; тус бүр 17% нь ардчилал: ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4) болон хүний эрхийн боловсрол (2.5) агуулгын хүрээнд тус тус илэрчээ. Харин хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх, уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1) гэсэн индикатораар нэг ч агуулга илрээгүй байна (Зураг II.B.2.1.).




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 238 агуулгын 171 буюу дийлэнх нь (71.8%) нь ТХ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 26.6% нь бага, 51.5% нь суурь, 22.2% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус илэрсэн байна. Түүнчлэн ТХ-ийн айд хамаарах нийт агуулгын 6% нь тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1) агуулгын хүрээнд; 8% нь эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2) агуулгын хүрээнд; 47% нь нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл (3.3) агуулгын хүрээнд; 9% нь хүрээлэл орчны тогтвортой байдал ба тогтворжсан байдал (3.4) агуулгын хүрээнд; 6% нь уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт, ул мөр (3.5) агуулгын хүрээнд; 1% сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч: нарны, далайн түрлэгийн, салхины, далайн давлагааны, гүний дулааны, биомассын (3.6) агуулгын хүрээнд; 6% нь экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7) агуулгын хүрээнд; 2% нь ТХБ, тогтвортой байдлын боловсрол, тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9) агуулгын хүрээнд; 11% нь хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10) агуулгын хүрээнд тус тус илэрсэн байна. Харин хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-тай холбоотой агуулга энэ айд илрээгүй байна (Зураг II.B.2.1.).




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 238 агуулгын 24 буюу 10 орчим хувь нь ДИ-ийн айд хамаарч байна. Тэдгээрийн 42% нь бага, 58% нь суурь боловсролын түвшинд илэрсэн ба бүрэн дунд боловсролын түвшинд нэг ч агуулга илрээгүй байна. Түүнчлэн ДИ-ийн айд хамаарах нийт агуулгын тус бүр 17% нь даяаршил (4.1) болон дэлхийн иргэншлийн боловсрол, дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-ын агуулгын хүрээнд; түүнчлэн тус бүр 4% нь дэлхийн иргэн ба иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийтийн бүлэг (4.2) болон олон талт соёл ба эрлийзчисэн холимог соёл (4.4) мөн цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5)-ийн агуулгын хүрээнд; 25% нь дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ буюу дэлхийн хэмжээнд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх (4.3) агуулгын хүрээнд; 29% нь үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8-ын) агуулгын хүрээнд тус тус илэрчээ. Харин дэлхийн түвшний өрсөлдөөн ба өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6) болон дэлхийн түвшин дэх тэгш бус байдал, ялгаатай байдал (4.7)-тай холбоотой агуулга эн айд илрээгүй байна (Зураг II.B.2.1.).


ТХБА илэрсэн судлагдахуунууд




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн нийт 3 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ЖТЭ-ийн айн жендерийн тэгш байдал (1.1) болон жендерийн үл алагчилал (1.2)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага болон суурийн тус бүр 1 судлагдахуунд; охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3) болон жендерийн мэдрэиж (1.4) мөн жендерийн харьцаа (1.5)-нд хамаарах агуулга бага болон бүрэн дундад илрээгүй ба суурийн тус бүр ижилхэн 1 л судлагдахуунд бүртгэгджээ. (Зураг II.B.3.1.).



Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн нийт 3 "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарах нэг ч агуулга бүрэн дунд боловсролын аль ч судлагдахуунд илрээгүй байна. Түүнчлэн эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2) болон ардчилал, ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4) мөн хүний эрхийн боловсрол (2.5)-д тус тус хамаарах агуулга суурь боловсролд илрээгүй ба багын тус бүр 1 судлагдахуунд илэрчээ. Харин нийгмийн шудлага ёс (2.3)-нд хамаарах агуулга бага болон суурийн тус бүр 1 судлагдахуунд илэрсэн байна (Зураг II.B.3.2).



Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн нийт 3 "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ТХ-ийн айн тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1)-д хамаарах агуулга бага ба бүрэн дундын тус бүр 2, суурийн 4 судлагдахуунд; эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2)-т хамаарах агуулга боловсролын бүх түвшинд тус бүр судлагдахуунд; нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл ба тогтвортой байдал (3.3)-д хамаарах агуулга бага болон бүрэн дундын тус бүр 3, суурийн 4 судлагдахуунд; хүрээлэл орчны тогтвортой байдал ба огтворжсан байдал (3.4)-д хамаарах агуулга багын 2, суурийн 6, бүрэн дундын 3 судлагдахуунд; уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт/ул мөр (3.5)-д хамаарах агуулга багад илрээгүй ба суурийн 2, бүрэн дундын 1 судлагдахуунд; сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч (3.6)-д хамаарах агуулга суурь болон бүрэн дундад илрээгүй ба багын 1 судлагдахуунд; экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7)-д хамаарах агуулга багын 3, суурийн 4, бүрэн дундын 1 судлагдахуунд; ТХ-ийн айн хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-д хамаарах агуулга багын 3, суурийн 5, бүрэн дундын 1 судлагдахуунд; ТХБ, тогтвортой байдлын болон тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага болон суурийн тус бүр 2 судлагдахуунд тус тус илэрсэн байна (Зураг II.B.3.3).




Хэл, хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн нийт 3 "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ДИ-ийн айн даяаршил (4.1)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага болон суурийн тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн иргэн, иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийт бүлэг (4.2)-т хамаарах агуулга бага болон бүрэн дундад илрээгүй ба суурийн 1 судлагдахуунд; **дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ: дэлхийн хэмжээнд сэтгэж нутгийн түвшинд үйлдэх (4.3)-эд хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; олон талт соёл ба эрлийзчисэн холимог соёл (4.4)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундад илрээгүй ба бага боловсролын 1 судлагдахуунд; цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5)-нд хамаарах агуулга суурьд илрээгүй ба бага ба бүрэн дундад тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн түвшин дэх тэгш бус байдал/ялгаатай байдал (4.7)-д хамаарах агуулга бага ба суурьд илрээгүй ба бүрэн дундын 2 судлагдахуунд; үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн иргэншлийн боловсрол болон дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага боловсролын 1, суурийн 2 судлагдахуунд тус тус бүртгэгдсэн байна. Харин дэлхийн түвшний өрсөлдөөн/өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6)-т хамаарах агуулга боловсролын бүх түвшний аль ч судлагдахуунд огт илрээгүй байна. (Зураг II.B.3.4.).**

4.3 ба 4.4 графикт ороогүй байна.

С. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний үр дүнгүүд

ЕБС-ийн 1-12 ангийн түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн хөтөлбөрийн шинжилгээнд **монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, англи хэл, орос хэл, хөгжим, дүрслэх урлаг, эрүүл мэнд, технологи, биеийн тамир 10** судлагдахууны хөтөлбөрийг хамруулсан

3. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний шалгуураар)




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн хувьд цөм хөтөлбөрөөс "Матриц 2"-ын тусламжтайгаар ялгаж тодорхойлсон нийт 111 агуулга бүртгэгджээ. Тэдгээрийн 32% нь бага боловсролд, 43% нь суурь боловсролд, 25% нь бүрэн дунд боловсролд илэрсэн байна. (Зураг II.C.1.).


Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн хувьд "Матриц 2"-т тодорхойлогдсон хөтөлбөрийн агуулга нь ТХБ-ын агуулгын бүх 4 айд илэрч бүртгэгдсэн ба тэдгээрийн 14% нь ЖТЭ, 16% нь ХЭ, 41% нь ТХ, 28% нь ДИ-ийн айд тус тус илэрчээ. (Зураг II.C.1.).

4. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний индикатораар)

ТХБА-тай холбогдох хөтөлбөрийн агуулга




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 111 агуулгын 16 буюу 14.4% нь ТХБА-ын ЖТЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 31 % нь бага, 38% нь суурь, 31% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус бүртгэгджээ. Түүнчлэн ЖТЭ-ийн айд хамаарах нийт агуулгын тус бүр 31% нь харгалзан жендерийн тэгш байдал (1.1) болон жендерийн үл алагчилал (1.2) агуулгын хүрээнд; 6% нь окид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3) агуулгын хүрээнд; 19% нь жендерийн мэдрэмж (1.4)-ийн агуулгын хүрээнд 13% нь жендерийн харьцаа (1.5)-ны агуулгын хүрээнд тус тус илэрсэн байна. (Зураг II.C.2.1.).




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 111 агуулгын 18 буюу 16.2% нь ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 67 % нь суурь, 33% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус бүртгэгдэж, бага боловсролын түвшинд огт илрээгүй байна. Түүнчлэн ХЭ-ийн айд илэрсэн нийт агуулгын 17% нь хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх, уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1)-ийн агуулгын хүрээнд 28% нь эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх

ба иргэний эрх чөлөө (2.2)-ний агуулгын хүрээнд; 33% нь нийгмийн шударга ёс (2.3)-ны агуулгын хүрээнд; 17% нь ардчилал: ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4)-ын хүрээнд 6% нь хүний эрхийн боловсрол (2.5)-той холбоотой агуулгын түрээнд тус тус илэрээн байна (Зураг II.C.2.1.).




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 111 агуулгын 46 буюу 41.4% нь ТХБА-ын ТХ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 35% нь бага, 43% нь суурь, 22% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн ТХ-ийн айд илэрсэн нийт агуулгын тус бүр 17.4% нь тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1) болон эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2) мөн нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл (3.3) агуулгын хүрээнд; 15.2% нь хүрээлэл орчны тогтвортой байдал ба тогтворжсан байдал (3.4) агуулгын хүрээнд; 6.5% нь сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч: нарны, далайн түрлэгийн, салхины, далайн давлагааны, гүний дулааны, биомассын (3.6) агццлгын хүрээнд; 10.9% нь экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7) агуулгын хүрээнд; 2.2% нь хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8) агуулгын хүрээнд; 8.7% нь ТХБ, тогтвортой байдлын боловсрол, тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9) агуулгын хүрээнд; 4.3% нь хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10) агуулгын хүрээнд тус тус илэрсэн байна. Харин уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт, ул мөр (3.5)-тай холбоотой агуулга энэ айд огт илрээгүй байна (Зураг II.C.2.1.).




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 111 агуулгын 31 буюу 27.9% нь ТХБА-ын ДИ-ийн айд хамаарч байна. Тэдгээрийн 45% нь бага, 32% нь суурь, 23% нь бүрэн дунд боловсролын түвшинд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн ДИ-ийн айд илэрсэн нийт агуулгын тус бүр

9.7% нь даяаршил (4.1) болон цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5) агуулгын хүрээнд; мөн тус бүр 12.9% нь дэлхийн иргэн ба иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийтийн бүлэг (4.2) болон дэлхийн түвшин дэх тэгш бус байдал, ялгаатай байдал (4.7) агуулгын хүрээнд түүнчлэн тус бүр 16.1% нь дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ буюу дэлхийн хэмжээнд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх (4.3) болон дэлхийн иргэншлийн боловсрол, дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9) агуулгын хүрээнд; 22.6% нь үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8) агуулгын хүрээнд тус бүр илэрсэн байна. Харин олон талт соёл баэрлийзчисэн холимог соёл (4.4) болон дэлхийн түвшний өрсөлдөөн ба өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6)-тай холбоотой агуулгууд энэ айд огт илрээгүй байна (Зураг II.C.2.1.).


ТХБА илэрсэн судлагдахуунууд




Түүх, нийгмийн ухааны үлэг хичээлийн нийт 4 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ЖТЭ-ийн айн жендерийн тэгш байдал (1.1)-д хамаарах агуулга бага ба бүрэн дундын тус бүр 1, суурийн 2 судлагдахуунд; жендерийн үл алагчилал (1.2)-д хамаарах агуулга суурьд илрээгүй ба бага болон бүрэн дундын тус бүр 1 судлагдахуунд; охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундад илрээгүй ба багын 1 судлагдахуунд; жендерийн мэдрэмж (1.4)-д хамаарах агуулга боловсролын түвшин бүрт тус бүр 1 судлагдахуунд; жендерийн харьцаа (1.5)-нд хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба бага болон суурийн тус бүр 1 судлагдахуунд тус бүр бүртгэгджээ (Зураг II.C.3.1).



Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн нийт 4 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарах нэг ч агуулга бага боловсролын аль ч судлагдахуунд илрээгүй байна. Түүнчлэн хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх, уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундын тус бүр 1 судлагдахуунд; эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2)-нд хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба суурийн 1 судлагдахуунд; нийгмийн шударга ёс (2.3)-нд хамаарах агуулга суурийн 2, бүрэн дундын 1 судлагдахуунд; ардчилал, ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4)-д хамаарах агуулга суурь ба бүрэн дундын тус бүр 1 судлагдахуунд; хүний эрхийн боловсрол (2.5)-д хамаарах агуулга бүрэн дундад илрээгүй ба суурийн 2 судлагдахуунд тус тус огт илэрсэн байна (Зураг II.C.3.2).



Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн нийт 4 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ТХ-ийн айн тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1) болон экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7) мөн ТХБ, тогтвортой байдлын болон тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-д тус тус хамаарах агуулга боловсролын түвшин бүрд тус бүр 1 судлагдахуунд; эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2) болон нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл ба тогтвортой байдал (3.3)-д хамаарах агуулга баг ба бүрэн дундын тус бүр 1, суурийн тус бүр 2 судлагдахуунд; хүрээлэл орчны тогтвортой байдал ба огтворжсан байдал (3.4)-д хамаарах агуулга суурьд илрээгүй ба бага болон бүрэн дундад тус бүр 1 судлагдахуунд; уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт/ул мөр (3.5)-д хамаарах агуулга бага болон бүрэн дундад илрээгүй ба суурийн 2 судлагдахуунд; сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч (3.6) болон ТХ-ийн айн хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-д хамаарах агуулга бага болон бүрэн дундад тус тус илрээгүй ба суурийн тус бүр 1 судлагдахуунд; хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10)-д хамаарах агуулга зөвхөн бага боловсролын 1 судлагдахуунд тус тус бүртгэгдсэн байна. (Зураг II.C.3.3).




Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн нийт 4 судлагдахууны "Матриц 2"-оос тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн агуулгын тухайд ТХБА-ын ДИ-ийн айн даяаршил (4.1) болон дэлхийн иргэн, иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийт бүлэг (4.2)-т хамаарах агуулга бага боловсролын түвшин бүрийн тус бүр 1 судлагдахуунд; цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5) болон дэлхийн түвшний өрсөлдөөн/өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6) мөн үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8) түүнчлэн дэлхийн иргэншлийн боловсрол болон дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9) гэсэн 4 индикаторт хамаарах агуулга суурь боловсролын аль ч судлагдахуунд илрээгүй ба бага болон бүрэн дунд боловсролын тус бүр 1 судлагдахуунд; дэлхийн түвшин дэх тэгш бус байдал/ялгаатай байдал (4.7)-д хамаарах агуулга бага болон бүрэн дундад илрээгүй ба суурийн 2 судлагдахуунд бүртгэгдсэн байна (Зураг II.C.3.4.).

Д. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулгын шинжилгээний үр дүнгүүд

ЕБС-ийн 1-9 ангийн бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр (СДҮА)-т иргэний боловсролын, амьдрах чадварт суралцах болон хичээлээс гадуурх гэсэн 3 үйл ажиллагааг авч үздэг.

1. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний шалгуураар)




Сургалтын дэмжих үйл ажиллагааны хувьд цөм хөтөлбөрөөс "Матриц 2"-ын тусламжтайгаар ялгаж тодорхойлсон нийт 81 агуулга бүртгэгджээ. Тэдгээрийн 33% нь бага боловсролд, 67% нь суурь боловсролд тус тус илэрсэн байна. (Зураг II.D.1.).


Сургалтын дэмжих үйл ажиллагааны хувьд "Матриц 2"-т тодорхойлогдсон хөтөлбөрийн агуулга нь ТХБ-ын агуулгын бүх 4 айд илэрсэн боловч тэдгээрийн тархалт жигд бус байна. Тухайлбал, нийт бүртгэгдсэн 81 агуулгын 77% нь "Тогтвортой хөгжил" агуулгын айд илэрсэн байхад "Жендерийн тэгш эрх" болон "Хүний эрх"-ийн агуулгын айд дөнгөж 6-7%, мөн "Дэлхийн иргэншил"-ийн айд 10% нь илэрчээ. (Зураг II.D.1.).

1. Цөм хөтөлбөрийн агуулгаас бүртгэгдсэн ТХБА-ын тархалт (боловсролын түвшин ба үнэлгээний индикатораар)


ТХБА-тай холбогдох хөтөлбөрийн агуулга




Сургалтыг дэмжих үйл ажиллагааны тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 81 агуулгын 5 буюу 6.2% нь ТХБА-ын ЖТЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 20% нь бага, 80% нь суурь боловсролын түвшинд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн ЖТЭ-ийн айд илэрсэн нийт агуулгын тус бүр 40% нь жендерийн тэгш байдал (1.1) болон жендерийн үл алагчилал (1.2)-ын агуулгын хүрээнд; 20% нь охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3)-ын агуулгын хүрээнд тус тус илэрчээ. Харин жендерийн мэдрэмж (1.4) болон жендерийн харьцаа (1.5)-тай холбоотой нэг ч агуулга илрээгүй байна (Зураг II.D.2.1.).



Сургалтыг дэмжих үйл ажиллагааны тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 81 агуулгын 6 буюу 7.4% нь ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээр нь бүгд суурь боловсролд бүртгэгджээ. Түүнчлэн ХЭ-ийн айд илэрсэн нийт агуулгын 17% нь хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх, уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1)-ийн агуулгын хүрээнд тус бүр 33% нь эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2) болон хүний эрхийн боловсрол (2.5)-ын агуулгын хүрээнд тус тус илэрчээ. Харин ардчилал: ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4)-тай холбоотой агуулга энэ айд илрээгүй байна (Зураг II.D.2.1.).




Сургалтыг дэмжих үйл ажиллагааны тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 81 агуулгын 62 буюу 76.5% нь ТХБА-ын ТХ-ийн айд хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн тус бүр 40% нь бага боловсрол, 60% нь суурь боловсролд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн ТХ-ийн айд илэрсэн нийт агуулгын 16% нь тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1)-ийн агуулгын хүрээнд; 11% нь эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2)-ийн агуулгын хүрээнд; 21% нь нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл (3.3) агуулгын хүрээнд; 8% нь хүрээлэл орчны тогтвортой байдал ба тогтворжсан байдал (3.4)-ын агуулгын хүрээнд; тус бүр 6% нь уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт, ул мөр (3.5) болон хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10)-ын агуулгын хүрээнд; 10% нь сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч: нарны, далайн түрлэгийн, салхины, далайн давлагааны, гүний дулааны, биомассын (3.6) агуулгын хүрээнд; 2% нь хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-ын агуулгын хүрээнд; 19% нь ТХБ, тогтвортой байдлын боловсрол, тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-ын агуулгын хүрээнд тус тус илэрсэн байна. Харин экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7)-той холбоотой агуулгын энэ айд илрээгүй байна (Зураг II.D.2.1.).




Сургалтыг дэмжих үйл ажиллагааны тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 81 агуулгын 8 буюу 10 орчим хувь нь ТХБА-ын ДИ-ийн айд хамаарч байна. Тэдгээрийн 12.5% нь бага, 87.5% нь суурь боловсролын түвшинд тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн ДИ-ийн айд илэрсэн нийт агуулгын тус бүр 12.5% нь дэлхий-нутаг сэтгэлгээ ба нутаг-дэлхий сэтгэлгээ буюу дэлхийн хэмжээнд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх (4.3) болон олон талт соёл ба эрлийзчисэн холимог соёл (4.4) мөн дэлхийн иргэншлийн боловсрол, дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-ын агуулгын хүрээнд; 25% нь дэлхийн түвшин дэх тэгш бус байдал, ялгаатай байдал (4.7)-ын агуулгын хүрээнд; 37.5% нь үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8)-ын агуулгын хүрээнд тус тус илэрчээ. Харин даяаршил (4.1) болон дэлхийн иргэн ба иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийтийн бүлэг (4.2) мөн цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5) түүнчлэн дэлхийн түвшний өрсөлдөөн ба өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6) гэсэн агуулгын энэ айн 4 индикатораар илрэх агуулга огт бүртгэгдээгүй байна (Зураг II.D.2.1.).


ТХБА илэрсэн судлагдахуунууд




"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны агуулгын тухайд ТХБА-ын ЖТЭ-ийн айн жендерийн тэгш байдал (1.1)-д хамаарах агуулга бага боловсролд илрээгүй ба суурийн 2 үйл ажиллагаанд; жендерийн үл алагчилал (1.2)-д хамаарах агуулга бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх (1.3)-д хамаарах агуулга багад илрээгүй ба суурийн 1 үйл ажиллагаанд тус тус илэрчээ. Харин жендерийн мэдрэмж (1.4) болон жендерийн харьцаа (1.5)-тай холбоотой агуулга боловсролын аль түвшний нэг ч үйл ажиллагаанд илрээгүй байна (Зураг II.D.3.1).



"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны агуулгын тухайд ТХБА-ын ХЭ-ийн айд хамаарах нэг ч агуулга бага боловсролын аль ч үйл ажиллагаанд илрээгүй байна. Түүнчлэн хүний эрх, үүрэг, хариуцлага: хүүхдийн эрх, хэл, соёлын эрх, уугуул иргэдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (2.1) болон нийгмийн шударга ёс (2.3) мөн хүний эрхийн боловсрол (2.5)-д хамаарах агуулга суурь боловсролын тус бүр 1 үйл ажиллагаанд; эрх чөлөө: үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх ба иргэний эрх чөлөө (2.2)-нд хамаарах агуулга суурийн 2 үйл ажиллагаанд тус илэрсэн байна. харин ардчилал, ардчилсан засаглал, ардчилалын үнэт зүйлс, зарчим (2.4)-тай холбоотой агуулга боловсролын аль ч түвшний нэг ч үйл ажиллагаанд илрээгүй байна. (Зураг II.D.3.2).



"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны агуулгын тухайд ТХБА-ын ТХ-ийн айн тогтвортой байдал, тогтвортой хөгжил (3.1)-д хамаарах агуулга бага болон суурийн тус бүр 2 үйл ажиллагаанд; эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, ногоон эдийн засаг (3.2)-т хамаарах агуулга багад илрээгүй ба суурийн 2 үйл ажиллагаанд; нийгмийн тогтвортой байдал: нийгмийн эв нэгдэл ба тогтвортой байдал (3.3) болон хүрээлэл орчны тогтвортой байдал ба тогтворжсан байдал (3.4)-д хамаарах агуулга тус бүр багын 2, суурийн 1 үйл ажиллагаанд; уур амьсгалын өөрчлөлт, тогтворгүй байдал: дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийн ялгаруулалт/ ул мөр (3.5) болон сэргээгдэх эрчим хүч/түлш, байгаль орчинд ээлтэй эрчим хүч (3.6)-д хамаарах агуулга бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт (3.8)-д хамаарах агуулга суурьд илрээгүй ба багын 1 үйл ажиллагаанд; ТХБ, тогтвортой байдлын болон тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.9)-д хамаарах агуулга багын 2, суурийн 3 үйл ажиллагаанд; хүрээлэл орчны боловсрол ба судалгаа, хүрээлэл орчны төлөөх боловсрол, хүрээлэл орчны тогтвортой байдлын төлөөх боловсрол (3.10)-д хамаарах агуулга багад илрээгүй ба суурийн 1 үйл ажиллагаанд тус тус бүртгэгдсэн байна. Харин экосистем, экологи: биологийн олон янз байдал, биосфер, биом, төрөл зүйлийн хомсдол (3.7)-д хамаарах агуулга боловсролын аль ч түвшний нэг ч үйл ажиллагаанд илрээгүй байна (Зураг II.D.3.3).



"Матриц 2"-оос бүртгэгдсэн сургалтыг дэмжих 3 төрлийн үйл ажиллагааны агуулгын тухайд ТХБА-ын ДИ-ийн айн даяаршил (4.1) болон дэлхийн иргэн, иргэншил, соёл, өвөрмөц байдал, олон нийт бүлэг (4.2) мөн цагаачилж явах, цагаачилж ирэх, шилжилт, шилжилт хөдөлгөөн (4.5) түүнчлэн дэлхийн түвшний өрсөлдөөн/өрсөлдөх чадвар, дэлхийн түвшний өрсөлдөгч, олон улсад өрсөлдөх чадвар (4.6) гэсэн 4 индикатороор тодорхойлогдох агуулга боловсролын бүх түвшний аль ч үйл ажиллагаанд огт илрээгүй байна. Харин дэлхийн түвшин дэх тэгш бус байдал/ялгаатай байдал (4.7)-д хамаарах агуулга бага болон суурийн тус бүр 1 үйл ажиллагаанд; үндэсний ба нутаг орны иргэншил, соёл, өвөрмөц байдал, соёлын өв ба дэлхийн иргэншлийн боловсрол (4.8)-д хамаарах агуулга багад илрээгүй ба суурийн 2 үйл ажиллагаанд; дэлхийн иргэншлийн боловсрол болон дэлхийн иргэншлийн төлөөх боловсрол (4.9)-д хамаарах агуулга багад илрээгүй суурийн 1 үйл ажиллагаанд тус тус бүртгэгдсэн байна. (Зураг II.D.3.4.).

IV. ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН АРГА БА ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын **арга зүй** хэрхэн тусаж, интеграцчилагдсан байдлыг үнэлэхийн тулд ЮНЕСКО-оос 2017 онд гаргасан “Тогтвортой Хөгжлийн Зорилгын төлөөх Боловсрол”² гэсэн удирдамжид санал болгосон ТХ-ийн 17 зорилго тус бүрийг хангахад хэрэглэж болох нийт 119 арга техникийг үнэлгээний шалгуур, индикатороор сонгох үндэслэл болгосон. Гэхдээ бид өмнө хийсэн судалгаагаар³ эдгээр 119 сургалтын арга техникийг харьцуулан судалж, 4 ай бүхий 20 тодорхой арга болгон төрөлжүүлсэн үр дүнгээ хэрэглэсэн. Тухайлбал, суралцахуйн арга зүйн дараах 4 айг шалгуур, тус бүрд нь харгалзах гол аргуудыг индикатор болгон ашигласан болно Үүнд:

- I. Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга: БХАОА (7)
- II. Шинжилгээ/ судалгаа хийх арга: ШСА (5)
- III. Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга: БШСА (4)
- IV. Алсын хараатай болох арга: АХА (4)

Сургалтын цөм хөтөлбөрийн арга зүйг шинжлэхдээ “арга зүй” гэсэн ерөнхий утгаар нь бус түүнийг ТХБА-ыг хэрэгжүүлэхэд хэрэглэж болох “арга” ба энэ аргыг хэрэглэхэд ашиглагдаж болох сургалтын “орчин ба хэрэглэгдэхүүн” гэсэн 2 чиглэлээр нарийвчлан шинжилсэн.

Сонгосон шалгуур индикаторынхоо тусламжтайгаар ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн арга зүйд шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.

A. Математик байгалийн ухааны бүлэг хичээлийн цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний үр дүнгүүд


² UNESCO, 2017. Education for Sustainable Development Goals: Learning Objectives.

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000247444>

³ БСШУСЯ, БМДИ, ШХА, 2018. ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй: Багшид зориулсан гарын авлага. УБ


ЕБС-ийн 1-12 ангийн математик, байгалийн ухаан (БУ)-ны бүлэг хичээлийн хөтөлбөрийн шинжилгээнд математик, мэдээлэл зүй, физик, хими, биологи, газар зүйн сургалтын хөтөлбөрүүд, сурал гэсэн 6 судлагдахууны хөтөлбөрийг хамруулсан. Шинжилгээг боловсролын бага, суурь, бүрэн дунд гэсэн 3 түвшингээр, ТХБА-ийн айн 4 шалгуур, сэдвийн 29 индикатораар явуулсан болно. ЕБС-ийн цөм хөтөлбөрүүдэд “агуулга” нь “суралцахуйн зорилтууд” хэлбэрээр тодорхойлогдсон байсан тул энэ судалгаанд хөтөлбөрийн агуулгыг үнэлэхдээ тэдгээр суралцахуйн зорилтуудаас энэ төрлийн судалгаанд зориулан судалгааны багаас тусгайлан бүтээсэн Матриц 2-ын тусламжтайгаар шинжлэх агуулгаа ялгаж үнэлсэн онцлогтой.

3. Хөтөлбөрөөс бүртгэгдсэн ТХБ-ын арга ба хэрэглэгдэхүүний тархалт (боловсролын түвшин ба шалгуураар)



Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд давхардсан тоогоор "Матриц 2 (М-2)"-оос 262, "Цөм хөтөлбөр (ЦХ)"-өөс 198, "Суралцахуйн удирдамж (БУ)"-аас 244, нийт 704 арга, техник тус тус бүртгэгдсэн байна. М-2, ЦХ, СУ дахь Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ)-ын аргуудын боловсролын түвшингүүд дэх тархалт нь жигд бус боловч ЦХ ба СУ хувьд ойролцоо дүр зурагтай байхад М-2-ын хувьд тархалтын жигд бус байдал нэмэгдсэн байна. Тухайлбал, М-2-оос бүрэн дунд боловсролд бүртгэгдсэн аргын эзлэх хувь ЦХ ба СУ-аас бага болон суурь боловсролд бүртгэгдсэн аргын эзлэх хувийн нийлбэрээс их байна. (Зураг III.A.1.1.)

Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд М-2, ЦХ, СУ-ийн аль альных нь арга зүйд ТХЗБ-ын арга зүйн бүх 4 айд хамаарах аргууд бүртгэгдсэн байгаа бөгөөд шинжилгээнд хамруулсан бүх эх баримтын хувьд тэдгээрийн тархалт нь жигд бус ч хоорондоо ижилэвтэр дүр зурагтай байна. Энэ бүлэг хичээлийн тухайд дээрх баримт бичгүүдэд ТХЗБ-ын арга зүйн шинжилгээ, судалгааны арга (ШСА) хамгийн их 40-53, бодит хамтын ажиллагаанд оролцох арга (БХАОА) 21-28, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээний арга (БШСА) 15-19, алсыг харах арга (АХА) 8-16 хувийг тус тус эзлэж байна (Зураг III.A.1.1.).




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд давхардсан тоогоор М-2-оос 195, ЦХ-өөс 125, "Суралцахуйн удирдамж СУ-аас 369, нийт 689 сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн тус тус бүртгэгдсэн байна. Сургалтын эдгээр орчин ба хэрэглэгдэхүүн (цаашид хэрэглэгдэхүүн гэнэ) нь ТХЗБ-ын арга зүй (704 арга)-г хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмээн тоологдсон болно. М-2, ЦХ, СУ дахь ТХЗБ-ын арга зүйд шаардагдах хэрэглэгдэхүүний боловсролын түвшингүүд дэх тархалт нь М-2-ын хувьд харьцангуй жигд байхад ЦХ ба СУ тус бүрийн хувьд харьцангуй жигд бус бөгөөд М2-оос ялгаатай дүр зурагтай байна. Тухайлбал, ЦХ ба СУ-аас суурь боловсролд бүртгэгдсэн хэрэглэгдэхүүний эзлэх хувь М2-оос суурь боловсролд бүртгэгдсэн хэрэглэгдэхүүний эзлэх хувиас бага байна. (Зураг III.A.1.2.)

Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд М-2, ЦХ, СУ-ийн аль альных нь арга зүйд ТХЗБ-ын арга зүйн бүх 4 айд хамаарах аргууд бүртгэгдсэн байгаа бөгөөд шинжилгээнд хамруулсан бүх эх баримтын хувьд сургалтын хэрэглэгдэхүүний тархалт нь жигд бус боловч ЦХ ба СУ нь хоорондоо ижилэвтэр, М2-т тэдгээрээс бага зэрэг ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Түүнчлэн М-2 дахь хэрэглэгдэхүүний тархалтын жигд бус байдал нэмэгдсэн бөгөөд ШСА-ын айд шаардагдах хэрэглэгдэхүүн нь бусад 3 айн нийт хэрэглэгдэхүүний нийлбэрээс их буюу 51%-д илэрсэн байна (Зураг III.A.1.2.).

2. Хөтөлбөрөөс бүртгэгдсэн ТХБ-ын аргын тархалт (боловсролын түвшин ба шалгуураар)

ТХБ-ын арга зүйтэй холбогдох М2, ЦХ, СУ-д тусгагдсан сургалтын аргууд




Математик, БУ-ны бүлэг хичээлийн тухайд "Матриц 2"-оос бүртгэгдсэн нийт 262 аргын 55 нь БХАОА-д хамаарч байгаа бөгөөд тэдгээрийн 35% нь бага, 13% нь суурь, 53% нь бүрэн дунд боловсролын түвшинд

тус тус бүртгэгдсэн байна. Түүнчлэн тэдгээрийн 11% нь БХАОА-ын айн тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх (1.1)-д; 5% нь аян, компанит ажилд оролцох, зохион байгуулах (1.2)-д; 7% нь дадлага (internship) хийх (1.4)-д; 49% нь үйл ажиллагаанд оролцох, хамрагдах, төлөвлөх (1.5)-д; 16% нь үйл ажиллагааны төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, оролцох (1.6)-д; 11% нь видео үзэх (1.7) аргад тус тус илэрсэн байна. Харин сургалтын аргын энэ айн хүрээнд түншлэл (partnership)-ийг хөгжүүлэх (1.3) арга илрээгүй байна. (Зураг III.A.2.1.1).

